



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар A/05

Жаргалтхаан

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд 2025 онд сумын Засаг даргын Тамгын газрын “Цэвэр тохилог Жаргалтхаан хөтөлбөрийн зардал”-аар хийгдэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Отгонбаяр – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Н.Энхзул–Архив, бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд: Т.Сүрэнцэцэг – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Г.Түмэнжаргал- Байгаль орчны асуудал

хариуцсан мэргэжилтэн

Г.Жавзанжамъян - Нярав

2.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулах, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг үнэлгээний хороо (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА  С.ГАНБАТ